



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2019 оны 12 сарын 20 өдөр

Дугаар А/876

Ховд

Хөрөнгө гаргах тухай

Монгол Улсын Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2018 оны 8 дугаар хуралдааны 8/04 дүгээр тогтоолын 5 дугаар хавсралтын 5.3 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Ховд аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2019 оны 5 дугаар сарын 31-ний өдрийн 28 дугаар тогтоолоор “Хэвлэл мэдээллийн тогтвортой хөгжлийг дэмжих хөтөлбөр”-өөс Ховд аймгийн хэвлэл мэдээллийн байгууллагад ажиллаж буй сэтгүүлчдийг сургаж, чадавхжуулах, ажиллах нөхцлийг нь сайжруулах, сэтгүүлчдийг бие даан хөгжихөд дэмжлэг үзүүлэх зардалд 22 700 000 төгрөгийг хавсралтаар баталж зарцуулсугай.

2.Хөтөлбөр хэрэгжүүлэхэд зориулан зарцуулагдах 22 700 000 төгрөг /Хорин хоёр сая долоон зуун мянган/-ийг Орон нутгийн хөгжлийн сангийн 5.35-д тусгагдсан “Хэвлэл мэдээллийн тогтвортой хөгжлийг дэмжих хөтөлбөр”-өөс гаргахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга /Ч.Багдал/-д зөвшөөрсүгэй.


3.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга /Д.Энхболд/-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Б.ДҮГЭРЖАВ

Аймгийн Засаг даргын 2019 оны
12 дугаар сарын 20-ны өдрийн А/876 дугаар
захирамжийн хавсралт



Д/д	Зардлын нэр	Хийх ажил	Нэг бүрийн үнэ	Тоо ширхэг	Нийт үнэ
1	Олон нийтийн мэдэх эрхийг хангаж ажиллах	Иргэдийг хууль эрхзүй, иргэдийн оролцоо, боловсрол, эрүүл мэндийн чиглэлийн контент бэлтгэх	833,333	9	7,500,000
2		Телевизүүд сард 3-аас доошгүй ил тод байдлыг хангасан контент бэлтгэн түгээх			
3		Сонин, цахим сайтууд дээрх чиглэлийн булан ажиллуулж, сард 3-аас доошгүй нийтлэл бэлтгэн түгээх			
4	Ажиллах нөхцөл, нийгмийн асуудлыг сайжруулах	Мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэхэд шаардлагатай багаж хэрэгсэл, ном сурах бичгээр хангах	444,444	9	4,000,000
3	Чадавх бэхжүүлэх, инноваци нэвтрүүлэх	Телевизийн сэтгүүлзүй, сонины бичлэгийн төрөл зүйл, арга барил, график дизайн, эвүүлгийн чиглэлээр чадавхжуулах сургалтад хамруулах	611,111	8	5,500,000
4	Мэргэжил, ур чадварыг хөгжүүлэх, үр нөлөөг дээшлүүлэх	Орчин үеийн сэтгүүлзүйн чиг хандлагыг төлөвшүүлж, нутагшуулах нь сургалт	444,444	9	4,000,000
5	Холбоо, харилцаа, хамтран суралцах явдлыг дэмжих		188,888	8	1,700,000
	Нийт				22,700,000